



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СҮМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 48

Шарга

Г

Г

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3/к/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ**:

1. "Галт дулаан" ОНӨААТҮГ-аас байгууллагынхаа хэвийн үйл ажиллагааг хангаж Алжаал тайлах байрны өргөтгөл, засвар хийх, 2 машины дулаан грах барих, Аварын шугам татахад нийт 22760150 төгрөг зарцуулах эрхийг зөвшөөрсүгэй.
2. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй захиран зарцуулж Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаж ажиллахыг "Галт дулаан" ОНӨААТҮГ-ын дарга Д.Мягмар, ня-бо /Г.Оюунчимэг/ нар үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ч.АЗБАЯР